

## **Баян-Өлгий аймгийн Статистикийн хэлтсийн дарга Хаби овогтой Бахытын ажил байдлын тодорхойлолт**

Хаби овогтой Бахыт нь 1961 онд төрсөн, Ам бүл 7, 1979 онд Өлгий хотын 10 жилийн 1 дүгээр дунд сургуулийн 10 дугаар анги, 1984 онд хуучин ЗХУ-ын Львов хотын Политехникийн дээд сургуулийг электроникийн инженер мэргэжилээр, 2006 онд МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг статистикч-эдийн засагч мэргэжлээр төгссөн, техникийн болон эдийн засгийн ухааны магистрын зэрэгтэй. 1984-1988 оны 10 дугаар сар хүртэл УБ хотын ЦШСГазарт автоматик-телемеханикийн инженер, 1988-1996 оны 10 дугаар сар хүртэл аймгийн АДХГЗахиргааны Төлөвлөгөөний хороо, статистикийн хэлтэст инженер-программист, ахлах мэргэжилтэн, 1997 оны 8 дугаар сараас одоог хүртэл Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэсийн даргаар ажилладаг, нийтдээ улсад 30 гаруй жил, үүнээс статистикийн байгууллагад 26 жил тасралтгүй ажиллаж буй тэргүүний сэхээтэний нэг.

Х.Бахыт нь 2000 онд ТАСИС хөтөлбөрийн шугамаар Франц улсын Тулон хотын информатикийн дээд сургууль болон Дани улсад тус тус мэргэжил дээшлүүлэх курс дамжаанд суралцан төгссөн, компьютерийн программист болон эдийн засгийн чиглэлээр мэргэжил эзэмшсэн, мэргэшсэн төрийн албан хаагчдын нэг. Ажлын гараагаа эрчим хүчний салбарт эхэлж, ажилласан хугацаанд 4 шинэ бүтээл оновчтой санал санаачлан үйлдвэрлэлд нэвтрүүлж, гар ажиллагааг автоматжуулахад өөрийн оюуны хөдөлмөрийг дайчлан ажилласан.

Аймгийн статистикийн байгууллагад ажиллаж байгаа хугацаанд албан ёсны статистикийн үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэх, мэдээ, тайлан мэдээллийг боловсронгуй болгох, бүртгэл статистикийн ажлыг арга зүйн зөвлөмж, мэргэжлийн удирдлагаар хангаж, энэ салбарт мэдээлэл холбооны технологийн ололт, дэвшилт техник технологи нэвтрүүлж, аймгийн Засаг даргын тамгын газарт компьютерийн дотоод сүлжээг өөрийн биеэр гардан зохион байгуулан хийж, интернэтийн сүлжээг аймагтаа анх ашиглалтанд оруулсан ба дотоод сүлжээнд БЭВ сайт хийх технологи, Үндэсний Статистикийн хорооны интернэт сайт дахь аймгийн статистикийн хэлтсийн порталыг БЭВ сайтыг шинэ мэдээ, мэдээллээр сард 2-оос доошгүй удаа баяжуулан, сүүлийн шинэ программ хангамжуудыг нэвтрүүлэн энэхүү сүлжээгээр дамжуулан ЗДТГ-ын удирдлагуудыг цаг үеийн болон нийгэм эдийн засгийн статистикийн тоо мэдээлэлээр ханган ажилладаг ба сум орон нутгийг компьютержуулах, хүн ам, өрхийн мэдээллийг цахим хэлбэрт оруулах ажлыг гардан хийж гүйцэтгэн, аймгийн хүн амын нэгдсэн сан байгуулах, статистик мэдээллийн ажлыг механикжуулах, автоматжуулах ажилд он удаан жил идэвхи зүтгэл үр бүтээл гарган ажиллаж, статистикийн албыг хөгжүүлэх, материаллаг баазыг бэхжүүлэх, ажиллагсадын ажиллах орчныг сайжруулах, нийгмийн баталгааг хангахад үнэтэй хувь нэмэр оруулж, өөрийн оюун ухаан мэдлэгээ дайчлан ажиллаж байгаа манай тэргүүний удирдах ажилтаны нэг. Аймгийн эдийн засаг, нийгмийн байдлын тухай статистикийн танилцуулга бюллетенийг хэвлэлийн стандартад нийцүүлэн шинэ загвараар хийсэн ба өөрсдийн санаачлагаар жил бүр 4-5 нийгэм эдийн засгийн тодорхой сэдэвийг сонгон авч тоцоо судалгааны ажлуудыг хийж аймаг, сумын удирдлагууд болон нийт хэрэглэгчидийн статистикийн мэдээллийн хэрэгцээг ханган ажилласан.

Х.Бахыт нь өөрийн мэдлэг мэргэжлээ дээшлүүлсэнээр хязгаарлахгүй тамгын газрын аппаратын болон өөрийн хэлтсийн ажилтнуудыг компьютерт сургах, анхан шатны баримжаа олгохоос аймгийн төвийн төсвийн болон банк санхүүгийн байгууллагын ажилтануудыг компьютерийн сургалтанд хамруулах, сурагчдад компьютер заах ажиллагаанд олон жил идэвхтэй ажиллаж ирлээ.

Хүн ам орон сууцны 2000, 2010 оны тооллогын ажлыг гардан амжилттай зохион байгуулан явуулсан, үр дүнг тархаасан, эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудын үзүүлэлтээр статистикийн олон жилийн динамик мэдээлэлийн сан байгуулах, жил бүрийн аймгийн ДНБ тооцоо зэрэг ажлуудыг орон нутагт амжилттай зохион байгуулан явуулж, санаачлагатай, идэвх зүтгэл гарган ажилласан болно.

Х.Бахытын удирддаг Статистикийн хэлтэс нь системийн байгууллагуудын дотроос 1999 оны ажлаараа нэгдүгээр байр, 2002 оны ажлаараа гуравдугаар байр эзэлж, хамт олон нь ҮСГ-ын “Өргөмжлөл”, иж бүрэн Pentium-4 компьютерээр шагнагдсан, 2006 онд тэргүүн байр, 2009 онд 2-р байр, 2010 онд 3-р байр, 2012 онд ажлаараа салбарын хэмжээнд 1-р байр эзэлж ҮСХорооны “Өргөмжлөл” мөнгөн шагналаар шагнагдсан. Хэлтсийн дарга Х.Бахыт нь Бүгд Найрамдах Солонгос Улсад туршлага судлах, суралцах аялалд оролцсон, 2012 онд Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын, 2013 онд Япон улсын “СИМФОНИКА” байгууллагын урилгаар тус улсын статистикийн байгууллагын туршлагыг тус тус судласан, Удирдлагын акедемид “төрийн удирдлага, манлайлал” хөтөлбөрт сургалтанд суралцсан, 2006 онд системийн байгууллагуудын дотроос тэргүүн байр, 2007, 2009, 2011, 2012, 2013 онуудад ажлаар салбарын хэмжээнд эхний тавьд байнга шалгаран ҮСХ-ны “Өргөмжлөл” мөнгөн шагналаар шагнагдсан Монгол Улсын Статистикийн салбарын үйл ажиллагаанд өөрийн бодитой хувь нэмрээ оруулан хамт олноо удирдан манлайлж, идэвхи санаачлага, үр бүтээлтэй ажилласан тэргүүний сэхээтэн юм.

Хэлтсийн ажлыг төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн хуультай уялдуулан зохион байгуулж, үндсэн үйл ажиллагааг бүтээгдэхүүнээр тооцох, хүн өдөрт хувиарлах, үр дүнг тооцох зэрэг шинэлэг зүйлийг өөрийн ажилд үлгэр жишээчээр нэвтрүүлэн хэрэгжүүлж байна.

Х.Бахытын статистикийн байгууллагад үр бүтээлтэй хөдөлмөрлөж байгаа бүтээлч хөдөлмөрийг үнэлж, 2000 онд салбарын шагнал “Бүртгэл статистикийн тэргүүний ажилтан” цол тэмдэгээр, 2004 онд төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн хүндэт” медалиар, 2009 онд “Алтангадас” одонгоор тус тус шагнагдсан.